



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН-2023



# Тайлангийн агуулга

A

Компанийн танилцуулга, 2023 оны үйл  
ажлагааны зорилго зорилтууд

B

Санхүү, эдийн засгийн гол үзүүлэлтүүд,  
статистик тооцоолол

B

Хөрөнгө оруулалт, ургал засвар,  
шинэчлэлтийн ажлууд

C

Олон нийтийн үйл ажиллагаа, тусlamж  
дэмжлэг, хүндэтгэл

D

Стандарт, төлөвлөгөөт хяналт  
шалгалт

1941 онд “Талхан завод” нэртэй байгуулагдаж эдүгээ 82 дахь жилдээ үйлдвэрлэл, борлуулалт худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүнсний ууган үйлдвэр билээ.

Бид хэрэглэгчдийн таашаалд нийцсэн талх талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэж ажиллахын зэрэгцээ хүнсний аюулгүй байдал, чанар эрүүл ахуйг эрхэмлэсээр ирсэн бөгөөд чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг 2022 онд дахин баталгаажуулан ISOICO/IEC 17025-2007 стандартад нийцсэн итгэмжлэгдсэн дотоод лабораторитоо түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүнд хими, микробиологийн шинжилгээг тогтмол хийж ард түмнээ чанарын баталгаатай хүнсээр хангах үүргээ биелүүлэн манай хамт олон хүнсний ууган үйлдвэрийнхээ нэгэн үеийн түүхийг өдөр бүр бүтээж урагшилсаар байна.



Компанийн  
танилцуулга,  
2023 оны үйл  
ажилагааны  
ерөнхий чиглэл

- ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, чанарын олон улсын стандартын дагуу технологийн шинэчлэлийг нэвтрүүлэн чанартай бүтээгдэхүүнийг соёлтой үйлчилгээгээр хүргэх нь бидний эрхэм зорилго юм.

- АЛСЫН ХАРАА

“Атар Өргөө” талхны ууган үйлдвэрийн хурилтлуулсан баялаг туршлага, Монгол эх орны хөрсөнд тарьж ургуулсан цэвэр түүхий эдээр амт чанарыг хослуулан, бүтээгдэхүүний өрөлдөх чадварыг дээшлүүлэн хүнсний үйлдвэрийн салбарыг үргэлж манлайлан хөгжих болно.

- ҮНЭТ ЗҮЙЛ:

Хуулийн хүрээнд ажиллах

Ажилдаа өөриймсөг ханддаг, ёсзүйтэй мэргэшсэн ажилтнууд

**Компанийн  
танилцуулга,  
2023 оны үйл  
ажилагааны  
ерөнхий чиглэл**

**2023 онд дэвшүүлсэн зорилтууд:**

- **Материаллаг баазаа бэхжүүлэх,**
- **Хөдөлмөрийн хөлсний үнэлгээг шат дараалалтай нэмэгдүүлэх**
- **Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйг алба нэгж, үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт бэхжүүлэх**
- **Чадварлаг, тогтвортой хүний нөөцөөр багаа өргөжүүлэн тэлэх**
- **Ажлын байрны таатай нөхцлийг нэмэгдүүлэх**

**Компанийн  
танилцуулга,  
2023 оны үйл  
ажилагааны  
ерөнхий чиглэл**

## 1. Материаллаг баазаа бэхжүүлэх:

1.1 Олон жилийн түүхэн замналтай компанийн хувьд барилга байгууламж, шугам холбоо, дэд бүтцийн насжилт үүссэн урт хугацааны төлөвлөгөөт засвар шинэчлэлийн ажлууд ээлж дараатай үргэлжилсээр байгаа.

Тайлант онд I ба II үйлдвэрийн хэмжээнд нийт 437 сая төгрөгийн үнэлгээ бүхий тоног төхөөрөмж урсгал засвар хөрөнгө оруулалтын ажлуудыг өөрийн дотоод ажиллах хүчний нөөц боломжийг ашиглаж мөн холбогдох гадны байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлж ажилласаар байна.

1.2 Үүний зэрэгцээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хяналтын ажлын хүрээнд камержуулалт, түгээлтийн тээврийн хэрэгслүүдийг GPS төхөөрөмжүүдийн нэмэлт сайжруулалтыг хийлээ.

**Компанийн  
танилцуулга,  
2023 оны үйл  
ажилагааны  
ерөнхий чиглэл**

**2. Хөдөлмөрийн хөлсний үнэлгээг шат дараалалтай нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2023 онд:**

**2.1. Цалин хөлсийг шат дараалалтайгаар, алба нэгжээр ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр, хариуцлагын түвшин идэвх санаачлага түүнийг дэмжсэн урамшууллын системээр нэмэгдүүлэх зорилготой ажилласан. Үүний үр дүнд цалингийн зардал **5-27** хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.**

➤ 3. Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйг алба нэгж, үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт бэхжүүлэх.

3.1. Хүнсний үйлдвэрлэлийн орчинд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй нь үйлдвэрлэлээс гарч буй бүтээгдэхүүний чанар стандартыг чанд мөрдөж ажиллахын зэрэгцээ ажилтны эрүүл аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг ажлын байр тус бүрт заавар нэг бүрээр хэвшүүлэх, ажилтан шинээр ажилд орох бүрт эхнээс нь мөрдүүлж дадлагажуулах ажлууд байнга хийгдэж байна.

3.2 Нийт ажилтнуудыг Мэргэжлийн байгууллагын Сертификаттай сургалтанд хамруулж, онцгой үүрэг бүхий ажлын байруудад давтан зааварчилгааг өдөр тутамдаа өгч, компанийн хэмжээнд эрсдэлгүй хамт олон болохыг зорин ажиллаж байна.

Компанийн  
танилцуулга,  
2023 оны үйл  
ажиллагааны  
ерөнхий чиглэл


#### 4. Чадварлаг, тогтвортой хүний нөөцөөр багаа өргөжүүлэн тэлэх:

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл үүнийг дагасан дотоодын аж ахуй нэгжүүдийн өмнө тулгарч буй нийтлэг хүндрэл болох хүний нөөц, ажиллах хүчний тогтвортгүй байдал одоог хүртэл үргэлжилсээр байна.

Тиймээс тайлант оны чухал зорилтын нэг бол чадварлаг, эерэг хандлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байранд тогтворт сурьшилтай чадваржуулан, сургаж ажиллуулахад чиглэсэн хүний нөөцийн бодлогыг баримтлах, түүнд чиглэсэн санхүүгийн болон хөдөлмөрийн харилцааны уян хатан бодлого өөрчлөлт хөшүүргийг тухай бүрт авч хэрэгжүүлэн, богино болон урт хугацааны төлөвлөлтүүдийг хийн ажиллаж байна.


Компанийн  
танилцуулга,  
2023 оны үйл  
ажиллагааны  
ерөнхий чиглэл

## "АТАР ӨРГӨӨ" ХК-ИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ 2024 ОН




## • Хүний нөөцийн статистик-2023


### Боловсрол



### Ажилчдын насжилтын байдал



### Хүйсийн харьцаа



■ 18-24 насны ажилтан  
■ 25-29 насны ажилтан  
■ 30-34 насны ажилтан  
■ 35-39 насны ажилтан  
■ 40-44 насны ажилтан  
■ 45-49 насны ажилтан  
■ 50-54 насны ажилтан  
■ 60 болон түүнээс дээш

■ 25-29 насны ажилтан  
■ 30-34 насны ажилтан  
■ 35-39 насны ажилтан  
■ 40-44 насны ажилтан  
■ 45-49 насны ажилтан  
■ 50-54 насны ажилтан

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг 2022 онтой харьцуулахад 7 хувиар өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Өртөг өсөхөд хамгийн чухал нөлөөлөх үндсэн шалтгаан болох түүхий эд материалын үнийн өсөлт, үйлдвэрлэлийн ашиглалтын зардлын өсөлт, цалингийн нэмэгдэл шууд хамааралтай байдгаас,

- Үндсэн түүхий эд 1-р гурил оны эхэнд **1720** төгрөгөөр худалдан авалт хийж байсан бол жилийн эцэст **1970** төгрөг буюу **12 %**, элсэн чихэр **2700** төгрөг байсан бол жилийн эцэст **3820** төгрөг буюу **41%-ийн** үнийн өсөлт хүрсэн нь өртөг нэмэгдэх гол үзүүлэлт болж байна.
- Мөн 2023 онд цахилгаан, дулаан, уур, усны төлбөр нэмэгдсэн нь үйлдвэрлэлийн өртөгт шууд нөлөөлж байгаа юм.


• Санхүү, Эдийн засгийн гол үзүүлэлтүүд, статистик-2023

• Санхүү, Эдийн засгийн гол үзүүлэлтүүд, статистик-2023

Тайлант онд төлөвлөсөн цалин хөлсний өсөлт:

- I үйлдвэр -19%
- II үйлдвэр -27%
- Борлуулалтын албаны ажилтнуудын цалин 5%-18%,
- Цэвэрлэгээ, үйлчилгээний цалин 79%
- Техникийн алба-11% тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

- Борлуулалтын бүсчлэл, сувгийн менежмент, хяналтыг илүү нарийвалаар хөгжүүлэхийн тулд борлуулалтанд ашиглагдаж буй түгээлтийн 13 автомашинд GPS төхөөрөмжийг нэмэлтээр суурилуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Борлуулалтын захиалгын системд “Atar Urguu” апликацийн шинээр хөгжүүлэн, туршилтын шатанд ажиллаж байна. Энэхүү програм нэвтэрснээр бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийн хүртээмж, захиалга өгөх, шинээр харилцагч болох үйл явц илүү хялбар болж хэрэглэгч харилцагчиддаа ойртож буй явц юм.



- Хөрөнгө оруулалт, ургал засвар шинэчлэлийн ажлууд

- Хөрөнгө оруулалт, ургал засвар шинэчлэлийн ажлууд

## Дулааны шугам, хүйтэн усны хоолойн засвар

- Олон жилийн насжилт үүссэн дулааны шугам, хүйтэн усны хоолойг шинэчилэх ажлууд ээлж дараатай хийгдсээр байна.
- 1-р үйлдвэрийн дулааны өгөх буцах шугам болон хүйтэн усны газар доорхи /15 м/ шугам хоолой хаалтуудыг шинээр сольж, дулаалагыг хийж хэвийн ажиллагаанд оруулаа.



# УУСМАЛЫН ӨРӨӨ ДАМЖСАН БОХИРЫН ХООЛОЙН ЗАСВАР



ДОТОР ХООЛОЙ-ӨМНӨ



ДОТОР ХООЛОЙ-ДАРАА

— Элэгдэлд орж цоорсон, битүүрсэн бохирын хоолойг 25м суваг ухаж, зургийн дагуу шинэчлэв.





Бөглөрөл үүссэн бохирын хоолой



Шинэчлэлийн  
дараа



1-р үйлдвэрийн Тортны тасгийг нүүлгэж цахилгаан монтажыг шинэчлэн, автомат удирдлага бүхий гүйдэг хаалгатай төмөр бэхэлгээтэй вакум ханаар тусгаарлан агааржуулалтыг сайжруулав.

I ДҮГЭЭР ҮЙЛДВЭРИЙН  
УУСМАЛЫН ӨРӨӨНИЙ ХАНА  
ШАЛ ТААЗЫГ СОЛЬЖ, ХУУЧИН  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ  
ШИНЭЧЛЭХ АЖИЛ  
ҮРГЭЛЖЛЭН ХИЙГДСЭЭР  
БАЙНА.







І ДҮГЭЭР ҮЙЛДВЭРИЙН ТУРШИЛТЫН ӨРӨӨНД  
ЗАСВАР ХИЙЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН  
САЙЖРУУЛАЛТ ХИЙН, ЧИПТЭЙ ХААЛГА  
СУУРИЛУУЛАН ЦЕХИЙН ХЭМЖЭЭНД  
ХӨГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.






II ДУГААР ҮЙЛДВЭРИЙН  
СУРГАЛТЫН ӨРӨӨГ ИЖ БҮРЭН  
ЗАСВАР ХИЙН, ПРОЕКТОР  
ГЭРЭЛТҮҮЛЭГЭЭР  
ТОХИЖУУЛАВ.





II ДУГААР ҮЙЛДВЭРИЙН ШАТНЫ КОРИДОР,  
2 ДАВХРЫН КОРИДОР ХАНЫН БУДАГ ӨНГӨ  
ТӨРХИЙГ СЭРГЭЭЖ, ГЭРЭЛТҮҮЛГИЙГ  
ШИНЭЧЛЭВ.

II үйлдвэрийн  
2 давхрын ариун  
цэврийн өрөөг иж  
бүрэн засварлаж,  
тусгаарлах хаалгыг  
вакум хаалтаар  
шинэчлэн тохижуулав.



II үйлдвэрийн  
оффисын өрөөнд  
засвар хийж,  
гэрэлтүүлгийг  
шинэчиллээ.



Ажилчдын улаан буланд дуу чимээ тусгаарлагч акустик хавтанг байрлууллаа. Ажилчдынхаа чөлөөт цагаа өнгөрөөх хэсгүүдийг алхам алхамаар тохижуулсаар байна. Удаан жилийн насжилттай барилга байгууламжтай учир ажилчдын сэтгэл ханамж, ажлын байрны таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч орчин үеийн оффисын хэв загварт шилжүүлэхэд багагүй хөрөнгө хүч цаг хугацаа зарцуулах болон зарим хэсгийн барилгын чанар муудсанаас хэв загварыг өөрчлөн шинэчлэх ажлуудыг шат дараатай хийж байна.

“Агар-Өргөө” ХК-иас өндөр насын тэтгэвэрт гарсан ахмад настнуудаа Ахмадын зөвлөлөөр дамжуулан байнгын эргэх холбоотой байж, санал хүсэлтийг хүлээн авч баяр ёслол, хүнд хэцүү цаг үед нь компани хамт байсаар ирсэн.

**2023 оны сар шинийн баярыг тохиолдүүлан компанийн 137 ахмад настнуудад 2192 ширхэг тавгийн идээний 10,521,600 төгрөгийн унэ бүхий хэвийн боовыг бэлэг болгон өглөө.**

**80,90 нас хүрсэн 7-н ахмадад хүндэтгэл үзүүлж мөнгөн аяга гарын бэлэг**

$$\begin{aligned} 480,000 \text{ ₮} / \text{мөнгөн аяга} * 7 \text{ ахмад} &= 3,360,000 \text{ ₮} \\ 10,000 \text{ ₮} / \text{хадаг} * 7 \text{ ахмад} &= 70,000 \text{ ₮} \\ \text{Бүтээгдэхүүний дээж гарын бэлэг } 23,960 \text{ ₮} * 4 \text{ ахмад} &= 95,840 \text{ ₮} \end{aligned} \quad \left. \right\} 3,525,840 \text{ ₮}$$

**Компанид бүртгэлтэй ахмад настан таалал төгссөн учир гэр бүлд эмэгнэл илэрхийлж хүндтгэл үзүүлсэн байдал**

$$300,000 \text{ ₮} * 3 \text{ ахмад} = 900,000 \text{ ₮}$$

**Ажилчадаа үзүүлсэн тусlamж, дэмжлэг, хүндэтгэл**

Б.Галя / УЭХ 60 жилийн ойн медаль / -300,000 ₮

Т:Болорзаяа / тэргүүний ажилтан тэмдэгээр шагнагдсан / -100,000 ₮

Ч.Амарсайн / эмчилгээний зардал / - 500,000 ₮

М.Баярмаа / үер уснаас нүүх зардалд зориулж / -500,000 ₮

Б.Лхагвасүрэн / төрсөн эцэг нас барсан /-300,000 ₮

Өндөр настан С.Адъяа / тусlamж дэмжлэг/-500,000 ₮

**Нийт зардал =17,147,440 ₮**


Олон нийтийн  
үйл ажиллагаа,  
тусlamж дэмжлэг  
хүндэтгэл



Сар шинийн өмнө өндөр настанд тавгийн идээний хэвийн боов хүндэтгэл болгон өгдөг уламжлалтай



Компанид бүртгэлтэй ахмад настын 80, 90 насыг мэлааж мөнгөн аяга, гарын бэлгээр жил бүр хүндэтгэл үзүүлдэг.





06.01 хүүхдийн эрхийг  
хамгаалах өдөр



ХҮҮХДИЙН БАЙГУУЛАГА, ИРГЭН,  
САЙН ҮЙЛСИЙН ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛАГУУДАД  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДЭЭЖИЙН  
ХАНДИВ ӨГӨВ.



- Эрүүл мэндийн сайдын А/145 дугаар тогтоолын дагуу ХУДЭМН-тэй хамтран хагас жил тутам компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн шинжилгээнд тогтмол хамруулан ажиллаж байна.

- Онцгой байдлын дуут дохионы зарлан мэдээллийн дагуу хамт олноороо аюулгүй байдлын дадлага сургуулилт хийлээ.

Мэргэжлийн аргазүй, ур чадвар, хандлага, ажлын байрны төлөвшилтийн сургалтуудыг төлөвлөгөөний дагуу дотооддоо тогтмол зохион байгуулж нийтээрээ суралцсаар байна.

Манай хамт олон өдөр тутмын үйл ажилгаандаа “SAFETY FIRST” зарчмыг мөрдөж ажилладаг. Уурын их зогсолтын өдрүүдээр “Ошми” ХХК-тай гэрээлэн нийт ажилтнууддаа “ХАБЭА-н тухай төрөөс баримтлаж буй бодлого, үндсэн зарчим, ХАБЭА-н тухай хууль, Ажлын байранд тавигдах шаардлага, стандартыг хангаж ажиллах, үйлдвэрийн осол, хурц хордлого гарах шалтгаан, эрсдэл, урьдчилан сэргийлэх, ажлын байрны эрсдлийн үнэлгээ хяналт, төрийн хяналтын тухай сургалтыг авч ажилтан, албан хаагчид мэдлэгээ баяжууллаа.





ISO 9001

# ГЭРЧИЛГЭЭ

"АТАР-ӨРГӨӨ" ХК

(Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан – Уул дүүрэг, 3-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө, "Атар – Өргөө" ХК –ийн байр)

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ

ISO 9001:2015

СТАНДАРТЫН ШААРДЛАГЫН ДАГУУ НЭВТРҮҮЛСЭН ТУЛ ОЛГОВ.

Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээ:

Талх, нарийн боовны үйлдвэрлэл

Бүртгэлийн №.117

Олгосон огноо: 2021.11.03

Анх олгосон огноо: 2017

Хүчинтэй огноо: 2024.11.04



БҮТЭЭГДЭХҮҮН, ТОГТОЛЦООНЫ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗАР



В.ГАНЗОРИГ

ISO9001:2015 олон улсын стандарт Чанарын менежментийн тогтолцоог 2017 оноос үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагын хүрээнд нэвтрүүлснээс хойш удаа дараа шалгуураа батлан ажиллаж байна.

ISO 9001:2015 стандарттаар чанарын байнгын сайжруулалтыг хэрэгжүүлэн дотоод хяналтын тогтолцоогоор хүнсний аюулгүй байдлыг хангаж, хэрэглэгчийн сэтгэл ханамж, харилцагч, түншүүдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн тэдний талархлыг хүлээсээр байна.

Стандарт,  
төлөвлөгөөт  
хяналт  
шалгалт

Стандарт,  
төлөвлөгөөт  
хяналт  
шалгалт



ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТОВ

## ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар TL 61

ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018)  
стандартын шаардлагыг хангасан

"Атар-Өргөө" ХК-ийн Хими, нян судлалын  
дотоод хяналтын лабораторийг

(Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн төвөөврөөн 20, Өврийн байр)

хавсралтад заасан итгэмжлэлийн хүрээнд  
корилт гүйцэтгүүлэхээр итгэмжлэв.

Энэ итгэмжлэл нь тодорхойлсон хүрээнд корилт гүйцэтгэх техникийн чадавхитай бөгөөд  
лабораторийн чанарын менежментийн тоогтолцоотой болохыг (ISO-ILAC-IAF-ын 2017 оны  
хамтарсан мэдээллийн үндэслэл) гэрчилнэ.

Анх итгэмжлэл авсан огноо:  
2010.06.24

Олгосон огноо: 2022.07.27  
Дуусах огноо: 2024.07.26

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
С.СОРОНЗОНБОЛД



0000742

**ISO 17025:2005 – "Атар-Өргөө" ХК**  
Хими, нян судлалын лабораторио  
итгэмжлүүлж "Сорилтын лабораторийн  
чадавхид тавих ерөнхий шаардлага" ISO/IEC  
17025:2005 олон улсын стандартын  
гэрчилгээг Стандартчилал Хэмжил Зүйн  
Газраас "**Салбартаа анхдагч**" -аар  
нэвтрүүлсэн амжилттай өдөр тутмын үйл  
ажиллагаагаа явуулж байна.

Мөн үйлдвэрлэлийн түүхий эдээ  
худалдан авахдаа хүнсний аюулгүй байдлын  
үндэсний лавлагаа лабораториор  
баталгаажуулахаас гадна итгэмжлэгдсэн  
дотоод лабораторидоо олон төрлийн  
үзүүлэлтээр шинжилж, стандарт ба  
техникийн шаардлагад нийцсэн түүхий эдийг  
олон талаас нь туршилтанд оруулж шаардлага  
хангасан тохиолдолд үйлдвэрлэлд  
нэвтрүүлдэг.

**Стандарт,  
төлөвлөгөөт  
хяналт  
шалгалт**

Тайлант онд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Хан-Уул дүүргийн мэргэжлийн хяналтын алба, Эрүүл мэндийн яамны ээлжит төлөвлөгөөт хяналт шалгалтууд хийгдэж амжилттай шалгуулж ажлаа дүгнүүллээ.

Манай хамт олон удирдлагын тогтолцоо, үйлдвэрлэл үйлчилгээний стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээс гадна тасралтгүй сайжруулж хамтдаа хөгжиж урагшилсаар байх болно.

